

БАТЛАВ  
НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН  
ЗАХИРАЛ  
Б.ЦОГТБААТАР

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2016.06.16

Тендер шалгаруулалтын нэр: *“Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн” гадна фасад, байрны дээврийн засвар, дулааны шугам засварын ажил /Улаанбаатар/-ын барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер.*

Тендер шалгаруулалтын дугаар: *НЭМХ-3-2016/06*

*Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн* эрх бүхий тендерт оролцогчдоос: *“Гадна фасад, байрны дээврийн засвар, дулааны шугам засварын ажил /Улаанбаатар/-ын барилгын ажлыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.*

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийн үнэ *100 000 (Нэг зуун мянга)* төгрөгийг НЭМХ-ийн Төрийн сан банкны 900015470 тоот дансанд тушаан худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн *45* хоногийн дотор хүчинтэй байна. Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

- *Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын дундаж нь санал болгож буй үнийн дүнгийн 50 хувьтай тэнцэх хэмжээтэй байна.*

- *Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ нь санал болгож буй үнийн дүнгийн 50 хувьтай тэнцэх хэмжээтэй байна.*

- *Сүүлийн 2 жил /2014, 2015 он/-ийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлнэ.*

- *Сүүлийн хоёр жилд санал болгож буй үнийн дүнгийн 30 хувьтай тэнцэх хэмжээний ижил төстэй ажлыг дор хаяж нэг удаа гүйцэтгэсэн байна,*

- *Барилга угсралтын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, сантехник, дулааны шугам сүлжээний засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл ирүүлэх шаардлагатай.*

Тендерийн хамт *2225000 төгрөг (хоёр сая хоёр зуун хорин таван мянга)* -ийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг *2016 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 14.00 цагаас* өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг *2016 оны 07 дугаар сар 18-ны өдрийн 14 цаг 30 минутад* нээнэ.

*Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй.*

*Дотоодын гүйцэтгэгчид давуу эрхийн зөрүү тооцохгүй.*

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

*Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 3 дугаар хороо Энхтайваны өргөн чөлөө 17, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн 314 тоот өрөө. Утас: 11-458645, 11-452672*